


PLITONIT

МЭРГЭЖИЛТЭН БАЙХ АМАРХАН



Plitonit
Deutsche
Qualität

PLITONIT COLORIT FAST CLINKER ХУУРАЙ ЗАЛГААСЫН ХОЛЬЦ PLITONIT Colorit Fast Clinker (ПЛИТОНИТ Колорит Фаст Клинкер)



Colorit Fast Clinker

Нүүрэн талын тоосго, чулуунцар болон бусад төрлийн хавтангаар хийсэн 30 мм хүртэлх өрлөгийн залгалтад зориулсан

Өнгөө алдахаас хамгаалах Таны гарын арьсанд зөөлөн гамтай*

2 нэгд орших - зуурмаг ба залгаасны цутгалт
Давсжилт үүсэхээс хамгаална

Өндөржүүлсэн хүйтэнд тэсвэртэй F150

Залгаасны нэмэгдүүлсэн бат бэх чанар ≥ 20 МПа

Хэрэглээний хүрээ

Өнгөт залгаасын хольц нь гадна болон дотор талын ажил хийхдээ өнгөлгөөний тоосго, чулуунцар хавтан, өнгөлгөөний керамик хавтан эсвэл өнгөлгөөний чулууны залгаасыг дүүргэх зориулалттай. Нийтийн эзэмшлийн талбай, орон сууц, тэр дундаа сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууламж (эмчилгээ, урьдчилан сэргийлэх, амралт-сувиллын байгууламжууд)-д, бага давхартай барилгад хэрэглэж болно.

Хэрэглэх зөвлөмж

Санал болгож буй залгаасны зузаан нь 6-30 мм. Санал болгож буй суурь: вааран, силикатын ба чулуунцар өнгөлгөөний тоосго, байгалийн болон хиймэл чулуу, чулуунцар хавтан, вааран хавтан. Үүнийг "нойтон шороо" хэлбэрээр товойлгон (хөөлгөн), эсвэл шүршдэг буу, товойлгосон лагтай уутаар чиглүүлэх замаар залгаасыг хийж болно.

Эхний аргыг нүүрэн талын тоосго, барзгар чулуунцар хавтан гэх мэт, хоёр дахь нь гөлгөр гадаргуутай хавтантай ажиллахад тохирохыг зөвлөж байна. Шинэ барилгын ажил, өрлөгийн үеийг шинэчлэхэд тохиромжтой. Энэ зуурмагийг барилгын нүүрэн өнгөлгөөний элемент болгон, PLITONIT Clinker Fix системд чулуунцар хавтангийн цавууны системтэй хамт ашигладаг.

Зуурмагийн ажлыг гүйцэтгэх өндөр хурдтай, цэвэрлэхэд амар, залгаа үүсгэхэд хялбар. Найрлага дахь тусгай ус холдуулагч нэмэлтүүд нь давсны давхарга үүсэхээс сэргийлдэг. Залгаасны сайжруулсан бат шинж чанар, хүйтэнд тэсвэртэй байдал нь гадна талын ажилд хэрэглэхэд урт хугацааны, найдвартай шийдэх боломжийг өгдөг. Савлагаа — 25 кг.

Пиктограмм/Техник үзүүлэлтүүд

- Гадна болон дотор талын ажилд зориулсан
- Залгаас 6-30 мм
- 12 цагийн дараа дээгүүр нь алхаж болно
- 24 цагийн дараа устай хүрэлцэж болно
- Хольцын амьдрах хугацаа (ажлын цаг) 2 цаг
- 3 минут холино
- Хүйтэнд тэсвэртэй байдлын марк F150
- Шахалтын үеийн бат бэх ≥ 20 Мпа
- Хэрэглэх температур $+5^{\circ}\text{C}$ хэмээс $+30^{\circ}\text{C}$ хүртэл
- Ашиглах үеийн температур -50°C хэмээс $+70^{\circ}\text{C}$ хэм хүртэл
- Хадгалах хугацаа 12 сар байна.

Өнгөний гамма: 11 өнгө

Бүтээгдэхүүний зарцуулалт*

240x71x10 мм шүршдэг буугаар түрхэхэд $\approx 2,5 \text{ кг/м}^2$ чулуунцар хавтангийн хувьд

240x71x10 мм "нойтон шороо" найрлагаар түрхэхэд $\approx 3,7 \text{ кг/м}^2$ чулуунцар хавтангийн хувьд

*Барилга угсралтын эхэнд хуурай хольцын зарцуулалтыг нарийн тодорхойлохын тулд залгаасны туршилтын дүүргэлт хийхийг зөвлөж байна.

Ажлын нөхцөл

Ажлын явцад болон гүйцэтгэлийн дараа 3 хоногт агаар, суурь, хавтангийн температур $+5$ хэмээс $+30$ хэмд байх ёстой. Ажлын явцад зуурмаг хольцын температур $+10$ хэмээс $+30$ хэмд байх ёстой. Ашиглалтын температур $+70^{\circ}\text{C}$ хүртэл байна. Зуурмагийг мөн гадаа ашиглах боломжтой. Энэ төрлийн ажлын хувьд залгаасны гадаргууг ажлын явцад болон дараагийн 24 цагийн турш хур тунадаснаас хамгаалсан байх ёстой.

Суурийг бэлтгэх

Залгаасны доорх суурийг шороо, тоосноос цэвэрлэж, салбарсан хэсгүүдийг арилгана. Залгаасны гүн нь хавтангийн зузааны хагасаас багагүй байх ёстой. Залгаасны цутгалтыг хэлбэржүүлэн цавуун зуурмагийн хольцын үйлдвэрлэгчээс тогтоосон хугацаанд хийх ёстой.

Зуурмагийн хольц бэлтгэх

Хуурай хольцыг нийлүүлж холихдоо нийтийн усны хангамжийн усыг ашиглах боломжтой. Холих харьцаа:

Өнгө	1 кг хуурай хольц/25 кг уутанд "нойтон шороо" хэлбэрээр жигд түрхэх	1 кг хуурай хольц/25 кг уутанд шүршдэг буугаар болон уутаар чиглүүлэх замаар залгаасыг түрхэх
Цагаан, шаргал, цайвар хүрэн, шар өнгөтэй	0,14-0,16 үс/3,5 -4,0 л үс	0,24 0,27 үс/6,0 -6,75 л үс
Саарал, хар саарал, бал чулуун, хар, хүрэн, шоколадан бор, тоосгон өнгөтэй	0,10-0,12 үс/2,5 3,0 -6,75 л үс	0,17-0,20 үс/4,25 -5,0 л үс

Хуурай хольцыг тасалгааны температурт урьдчилан хэмжсэн зохих хэмжээний ус уруу хийнэ, нэгэн төрлийн жигд болтол нь 2-3 минутын турш эргэлтийн хүрд нь 600 эргэлт/мин-ээс ихгүй байх цахилгаан холигч эсвэл цахилгаан өрмийн түслэмжтайгаар холино. Зуурмагийг ойролцоогоор 5 минут амраан дахин холино. Энэ үед зөвшөөрөгдсөн хамгийн дээд хэмжээний үлдсэн усыг нэмж хэрэглэж болно. Бэлэн зуурмагийг хэрэглэх хугацаа нь 2 хүртэлх цаг байх бөгөөд агаарын хэт халалт болон нэвт салхижуулалт энэ хугацааг багасахад нөлөөлнө.

Ажлын дараалал

"Нойтон шороо" хэлбэрээр товойлгон (хөөлгөн) залгаасыг хийхэд:

Залгаасны зуурмагийг "шинэ дээр шинэ" техникээр хоёр давхаргаар түрхэж, холбогч ашиглан даралтаар тэгшилнэ. Тэгшхэн, нэг төрлөөр түрхэх боловсруулах нь залгаасны дараачийн өнгөний нэгэн төрлийн байдлыг хангаж өгдөг. Ажлын завсарлагын үеэр өрлөгийг бүтээн хааж орхих хэрэгтэй.

Шүршдэг буу, товойлгосон лагтай уутаар чиглүүлэх замаар залгаасыг хийх үед:

Тусгай шүршдэг буу болон товойлгосон лагтай уутаар чиглүүлэх замаар залгаасыг бүрэн дүүргэн хийнэ. Тариурын буу болон товойлгосон лагтай уутаар чиглүүлэх замаар хавтан хоорондын залгаасны зуурмагийг түрхэнэ. Тэгшхэн, нэг төрлөөр түрхэх боловсруулах нь залгаасны дараачийн өнгөний нэгэн төрлийн байдлыг хангаж өгдөг. Зуурмагийг ижил түвшний барьцалдах үед залгаасыг үргэлж тэгшлэх хэрэгтэй. Залгаасны гадаргуу барьцалдан тогтсоны дараа тэр даруй хавтанг цэвэрлэх хэрэгтэй. Залгаасны гадаргуу барьцалдан тогтсоныг гараар хүрэх замаар шалгана ("эрхий хурууны" тест). Хавтангийн гадаргууг үрэгчтэй хөөсөнцөр ашиглан залгаас уруу диагоналиар цэвэрлэнэ. Гэхдээ залгаасны зуурмагийг их усаар зайлуулан угааж болохгүй.

залгаасны зуурмагийг усаар зайлуулагдан угаагдаж байвал зуурмаг хатуурах шаардлагатай үе шатанд хараахан хүрээгүй байна гэсэн үг юм. Цэвэрлэх усаа байнга сольж байх ёстой. Гадаргууг бүрэн цэвэр болтол үлдсэн зуурмагийн үлдэгдлийг угаана. Цэвэрлэгээ нь зуурмагийн үлдэгдлээс өнгөлгөөний материалын гадаргууг цэвэрлээд эцэст нь хуурай зөөлөн даавуугаар арчсанаар дуусдаг.

Анхааруулга

Ажлыг гүйцэтгэхдээ барилгын ерөнхий ажил гүйцэтгэх зааварчилга, барилга угсралтын ажилд мөрдөгдөх аюулгүй ажиллагааны зааварчилга дагаж мөрдөх ёстой. Өнгө нь багц, багцаас хамаарч өөр өөр байж болох учир худалдан авахдаа багцын дугаарт анхааралтай хандаарай. Дараах хүчин зүйлүүд нь өнгө болон, түүний жигд тархалтад нөлөөлж болно: хавтангийн анхны хуурай цэвэрлэгээ; чийгшил бага болон өндөр температур; нарны шууд тусгал, нэвт салхи; залгаасны гүний ялгаа; холих усыг хэтрүүлэн хэрэглэх, түүний чанар; суурийн илүүдэл чийг; хавтангийн хажуугийн ирмэгийн болон нүүрэн талын өнгөлгөөний тоосгоны өөр өөр шингээх чадвар; жигд бүс хольсон зуурмаг. Гялгар биш болон барзгар хавтангийн хоорондох залгаасны зуурмаг хийхээс өмнө зуурмагийн хольцын үлдэгдлийг хавтангаас хэр зэрэг сайн угааж байгааг шалгах шаардлагатай. Ажил гүйцэтгэх явцад зуурмагийг үе үе хольж байх ёстой. Бэлэн болсон хольц дээр нэмэлт ус нэмж хийхийг хориглоно. Зэвэрсэн багаж хэрэгслийг ашиглахыг хориглоно. Зуурмагийн ашиглалтын хугацаа нь усны температур, хуурай хольцын температур, орчны температураас хамаарч өөр өөр байж болно. Хэрэв агаарын температур +20 хэмээс +30 хэмийн хооронд байвал ажил эхлэхийн өмнө залгаасыг нэмэлт чийгшүүлэх хэрэгтэй.

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Хольц нь ОХУ-ын стандарт хэмжилзүйн газрын ГОСТ 12.1.007 стандартын дагуу аюулын 4-р (бага аюултай бодис) ангилалд хамаарна. Ажил гүйцэтгэхдээ бээлий, нүдний шил, амны хаалт хэрэглээрэй. Хольцыг арьс, нүдэндээ хүргэхээс зайлсхийх. Нүдэнд хүргэсэн тохиолдолд нэн даруй их хэмжээний усаар зайлна. ХҮҮХДЭЭС ХОЛ БАЙЛГА!

Орц, найрлага Элс, портланд цемент, эрдэс дүүргэгч, өөрчлөгч нэмэлт бүтээгдэхүүнүүд

Тээвэрлэлт болон хадгалах нөхцөл

Хуурай хольцыг ачаа тээвэрлэх дүрмийн дагуу бүрхүүлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Хуурай хольцтой уутыг савлагааны аюулгүй байдал, чийгээс хамгаалсан хаалттай хуурай өрөөнд хадгална.

Үйлдвэрлэгчийн баталгаа

Хэрэглэгч тээвэрлэх, хадгалах нөхцөл, энэхүү гарын авлагад заасан зааврыг дагаж мөрдсөн тохиолдолд хольц нь техникийн үзүүлэлтүүдийн шаардлагад нийцэж байгааг үйлдвэрлэгч баталгаажуулна. Үйлдвэрлэгч нь материалтай ажиллах технологийг дагаж мөрдөхгүй байх, түүнчлэн эдгээр зааварт заагаагүй зорилго, нөхцөлд ашиглах үед хариуцлага хүлээхгүй. ГОСТ 8.579-2019 стандартын дагуу цэвэр жингийн хазайлт байна.

Бүтээгдэхүүнийг бүх төрлийн иргэний барилгад ашиглахыг зөвшөөрсөн. (Аэфф<370 Бк/кг байх ОХУ-ын Цацрагийн аюулгүй байдлын стандартууд НРБ-99/2009, ариун цэврийн дүрэм, журам СанПиН 2.6.1.2523-09 нийцсэн).

Техникийн нөхцөл 23.64.10-229-51552155-2022 дагуу үйлдвэрлэсэн

Техникийн зохицуулалтын системийн тэмдэгтэй

*Москва хотын Эрүүл ахуй, халдвар судлалын төвийн шинжээчийн дүгнэлтэд үндэслэн хольц нь арьсыг гэмтээх, мэдрэмтгий болгох үйлчилгээ үзүүлэхгүй. Нэг удаа хольцод хүрсний дараа арьсанд цочирсон нөлөө байхгүй, харин олон удаа хүрсний дараа энэ нь сүл нөлөө үзүүлсэн байдаг. Хувийн хамгаалах хэрэгслийг ашиглах нь энэхүү зааврын УРЬДЧИЛАН АЖИЛЛАГААНЫ хэсгийн дагуу хийгдсэн болно.

